



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 20 өдөр

Дугаар 1/653

Номгон

“Зөв-Амьдрал” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх
арга хэмжээний төлөвлөгөө батлах
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, аймгийн 2021 оны хөгжлийн төлөвлөгөөний 102 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Зөв-Амьдрал” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 2021-2024 оны төлөвлөгөөг нэгдүгээр, 2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний зардал 3.0 сая /төг / Гурван сая/-ийг Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга (С.Байгалмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулан ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангарав)-д үүрэг болгосугай.


4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Энхжаргал)-д даалгасугай.

ДАРГА

Д.МӨНХСАЙХАН

601210559

Аймгийн Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 12 өдрийн
 А.163 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



**“ЗӨВ-АМЬДРАЛ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ
 ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021-2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| Зорилго | | Архидан согтуурсанаас эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаарх өсвөр үе, иргэдийн мэдлэг хандлагыг дээшлүүлэх замаар согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг тоог бууруулах, архинд донтсон хамааралтай болсон иргэдийг эрт илрүүлж эмчлэн хяналт тавьж тэдгээр иргэдийг нийгэмшүүлэх, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад тавигдах шаардлагыг нэмж цэгийн тоог бууруулах, төрийн албан хаагчдын архины хэрэглээг бууруулж албан томилолт, амралт, зугаалгаар явахдаа архи огт хэрэглэдэггүй нэгнийгээ архиар шахдаг байдлыг таслан зогсоох, ард иргэдийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлж архигүй орчин бий болгох зорилгоор архигүй баг, сум, байгууллага болох цаашид “Архигүй Баянхонгор” байх үйлсийг хэрэгжүүлэхэд оршино. | | | | | |
|---|--|--|-------------------------------|--|---|------------------|------------------|
| № | Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа | Шаардагдах төсөв |
| 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. | 7. | 8. |
| Зорилт: Өсвөр үе болон иргэд, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх замаар архийг жигших сэтгэл зүйтэй болгох сургалт, сурталчилгаа, нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах. | | | | | | | |
| 1.1. | Согтуугаар үйлдэгдэх гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд бүх шатны засаг дарга, иргэдийн хурал, эрүүл мэнд, боловсрол, соёл урлаг, шашин, төрийн бус байгууллага, хувийн хэвшил, иргэдийн оролцоог жигд хангаж, тэднийг татан оролцуулж, санамж бичиг байгуулж, хамтран ажиллах. | Бүх салбарын оролцоо жигд хангагдсан байна. | Байгуулсан санамж бичгийн тоо | Орон тооны бус зөвлөл Сумдын салбар зөвлөл | Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл | 2021-2022 | - |
| 1.2. | Согтууруулах ундаа хэрэглэж гэмт хэрэг зөрчилд холбогдохоос | Урьдчилан сэргийлэх чиглэл | Хийгдсэн мессеж, | Аймгийн гэмт хэргээс | | 2021-2024 | 3 сая |


| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|------|---|---|---|---|---|-----------|-------------|
| | урьдчилан сэргийлэх чиглэл бүхий мессежийг иргэдийн гар утсанд илгээх, олон хандалттай телевизийн сувгаар энэ чиглэлийн контент бэлтгэж сурталчлах. | бүхий мессеж, контент хийгдсэн байна. | контентийн тоо | урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл | Цагдаагийн газар | | |
| 1.3. | Мах, ноос ноолуур зэрэг түүхий эд зарж борлуулдаг саруудад хууль бус архины худалдаа, зүй бус хэрэглээ, архины хамааралтай хүмүүсийн нөлөөнөөс малчдыг хамгаалахад чиглэсэн урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах. | Малчдыг хамгаалахад чиглэсэн урьдчилан сэргийлэх ажлууд зохион байгуулагдсан байна. | Зохион байгуулсан урьдчилан сэргийлэх ажлын тоо, чанар | Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл | Цагдаагийн газар | 2021-2024 | - |
| 1.4. | Архидалттай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг тусгайлан шалгуур үзүүлэлт болгон сум, баг, байгууллагын ажил дүгнэх үзүүлэлтэд оруулж дүгнэх, дэмжих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | Сум, баг, байгууллагын ажил дүгнэх үзүүлэлтүүдэд шинэчлэл, нэмэлт хийгдсэн байна. | Архидалттай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээний тоо | Хууль, эрх зүйн хэлтэс | Сумдын Засаг даргын Тамгын газар | 2021-2024 | 5 сая/төг |
| 1.5. | Согтууруулах ундаа хэрэглэхээс бүрэн татгалзаж бусдад үлгэрлэж байгаа сум, багийн иргэдийг ажлын байраар хангах, зээл олгох, санхүүгийн дэмжлэг үзүүлнэ. | Дэмжлэг бодитой хийгдсэн байна. | Дэмжлэг үзүүлсэн тоо, чанар | Сумдын Засаг даргын Тамгын газар | Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл | 2021-2022 | - |
| 1.6. | Архигүй орчин бүрдүүлсэн сум, баг, байгууллагын зохион байгуулсан үйл ажиллагааг бүх нийтэд сурталчлан мэдээлэх. | Сурталчилгааны ажил тухай бүр хийгдсэн байна. | Телевиз болон цахим орчинд нийтлэгдсэн сурталчилгааны тоо | Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хэвлэл мэдээллийн | Орон нутгийн телевиз | 2021-2024 | 1.0 сая/төг |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|-------|---|---|--|---|---|--------------|-------------|
| | | | | алба | | | |
| 1.7. | Сум, багийн ажлын албаны албан тушаалтнуудаас Гэр бүлийн хүчирхийлэл, архидан согтуурах явдлаас урьдчилан сэргийлэх, түүний хор уршгийг сурталчилсан шторк бэлтгэж, аймгийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудсуудаар түгээх ажлыг зохион байгуулах | Сурталчилгааны ажил тухай бүр хийгдсэн байна. | Урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн шторкийн тоо | Сумдын Засаг даргын Тамгын газар | Аймаг, сумдын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл | 2021-2024 | |
| 1.8. | Согтууруулах ундаа хэрэглэн тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас эрүүл мэнд нь хохирч хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг өөрсдийнх нь хүсэлтээр яриаг нь авч энэ төрлийн богино шторкууд хийж олон нийтийн сүлжээгээр давтамжтай дамжуулах. | Жилд 2 удаа шторк хийгдсэн байна. | Урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн шторкийн тоо | Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл | 2021-2024 | - |
| 1.9. | "Архигүй орчин" дэвжээ тэмцээнийг сумдын иргэд, насанд хүрээгүй хүүхдүүдийн дунд үе шаттайгаар зохион байгуулах. | Тэмцээн зохион байгуулагдсан байна | Архины хор хөнөөлийг иргэдэд сурталчилж, архиыг үгүйсгэх нийгмийн хандлага бий болсон байна. | Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл | Сумдын Засаг даргын Тамгын газар | 2021-2024 он | 3.0 сая/төг |
| 1.10. | "Архигүй хамт олон" хөдөлгөөн өрнүүлж, байгуулага хамт олныг алдаршуулах. | Хөдөлгөөн өрнүүлж, хэрэгжүүлсэн байна. | Төрийн албан хаагчдын согтуугаар үйлдсэн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын тоо | Цагдаагийн газар | Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар | 2021-2022 он | 3 сая/төг |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|--|--|---|---|---|--------------|----------|
| | | | | | зөвлөл | | |
| 1.11. | Цахим орчинд "Би архи хэрэглэдэггүй" challenge өрнүүлэх | Challenge өрнүүлсэн байна | Challenge-д хамрагдсан иргэдийн тоо | Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл | Сумдын Засаг даргын Тамгын газар | 2021-2024 он | - |
| 1.12. | Олон нийтийн газар, нийтийн эзэмшлийн болон гудамж талбай, орон сууцны орц, овоо толгод, хөшөө цогцолбор, цэцэрлэгт хүрээлэн зэрэг газрын ойр орчим дахь гэрэлтүүлэг, камержуулалтын тоог нэмэгдүүлэх. | Тус газруудын ойр орчимд гэрэлтүүлэг, камержуулалт хийгдсэн байна. | Хийгдсэн гэрэлтүүлэг, камержуулалтын өсөлтийн тоо | Цагдаагийн газар | Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл | 2021-2024 он | ГХУСАЗСЗ |
| Зорилт 2: "Архи байнга болон хэтрүүлэн хэрэглэгч, архинд донтох өвчтэй иргэдийг эрт илрүүлж урьдчилан сэргийлэх, эмчлэх, хяналт тавих арга хэмжээг үр дүнтэй болгож, нийгэмшүүлэх | | | | | | | |
| 2.1. | Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж орчиндоо айдас төрүүлдэг, удаа дараа эрүүлжүүлэгддэг архины хамаарал бүхий иргэдийг "Жаргалтай амьдрал төв"-д холбон зуучилж, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах. | Архинд донтох өвчтэй иргэдийг эмчилгээнд хамруулсан байна. | Эмчлэгдсэн иргэдийн тоо | Аймгийн Цагдаагийн газар | Баянхонгор сумын ЗДТГ "Жаргалтай амьдрал" төв | 2021-2024 | - |
| 2.2. | "Жаргалтай амьдрал төв"-ийн эмчилгээнд хамрагдаж архинд донтох эмгэгээсээ салсан иргэдийн сайн туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор жил бүрийн 12 дугаар сард "Өөрийгөө ялсан хүн" арга | "Өөрийгөө ялсан хүн" арга хэмжээг зохион байгуулна. | Зохион байгуулагдсан арга хэмжээний чанар, нөлөө | Баянхонгор сумын ЗДТГ | Аймгийн Цагдаагийн газар | 2021-2024 | 4 сая |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|------|--|---|--|------------------|--|-----------|-------|
| | санал хүргүүлэх. | | | | | | |
| 3.3. | Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар цагдаагийн байгууллагаас аймгийн Засаг даргад хүргүүлсэн санал, түүний шийдвэрлэлтийн талаар нэгдсэн бүртгэл хөтлөх. | Мэдээллийн сан бий болсон байна. | Журмын хэрэгжилтийн чанар | Цагдаагийн газар | Хууль, эрх зүйн хэлтэс | 2021-2024 | - |
| 3.4. | Согтууруулах ундаагаар үйлчилдэг худалдан борлуулдаг аж ахуй нэгжүүдэд мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалт зохион байгуулах. | Хяналт шалгалт зохион байгуулагдсан байна. | Хяналт шалгалтын тоо, чанар | Цагдаагийн газар | Хууль хяналтын байгууллагууд | 2021-2024 | - |
| 3.5. | Хууль, журам зөрчиж согтууруулах ундааг худалдан борлуулсан, үйлчилсэн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг иргэдээс төлбөртэй авах | Мэдээлэл өгсөн иргэдийн нууцлалыг хамгаалж энэ талаарх үйл ажиллагаа хэвшил болсон байна. | Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын тоо | Цагдаагийн газар | Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар | 2021-2024 | 2 сая |

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 20 өдрийн
 А/659 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



**“ЗӨВ-АМЬДРАЛ” АЙМГИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ
 ХЭРЭГЖҮҮЛЭХ 2021 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

| Зорилго | | Архидан согтуурсанаас эрүүл мэнд, гэр бүл, хамт олон, нийгмийн амьдралд учрах хор уршгийн талаарх өсвөр үе, иргэдийн мэдлэг хандлагыг дээшлүүлэх замаар согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг тоог бууруулах, архинд донтсон хамааралтай болсон иргэдийг эрт илрүүлж эмчлэн хяналт тавьж тэдгээр иргэдийг нийгэмшүүлэх, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрлийн хугацааг сунгахад тавигдах шаардлагыг нэмж цэгийн тоог бууруулах, төрийн албан хаагчдын архины хэрэглээг бууруулж албан томилолт, амралт, зугаалгаар явахдаа архи огт хэрэглэдэггүй нэгнийгээ архиар шахдаг байдлыг таслан зогсоох, ард иргэдийн амар тайван амьдрах нөхцлийг бүрдүүлж архигүй орчин бий болгох зорилгоор архигүй баг, сум, байгууллага болох цаашид “Архигүй Баянхонгор” байх үйлсийг хэрэгжүүлэхэд оршино. | | | | | |
|---|---|--|---|---|----------------------------------|------------------|------------------|
| № | Хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулах үйл ажиллагаа | Бүтээгдэхүүн | Шалгуур үзүүлэлт | Хэрэгжилтийг хариуцах байгууллага | Хамтран хэрэгжүүлэх байгууллага | Хэрэгжих хугацаа | Шаардагдах төсөв |
| 1. | 2. | 3. | 4. | 5. | 6. | 7. | 8. |
| Зорилт 1: Өсвөр үе болон иргэд, төрийн албан хаагчдын эрх зүйн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх замаар архийг жигших сэтгэл зүйтэй болгох сургалт, сурталчилгаа нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулах | | | | | | | |
| 1.1. | Согтууруулах ундаа хэрэглэж гэмт хэрэг зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх чиглэл бүхий мессежийг иргэдийн гар утсанд илгээх, олон хандалттай телевизийн сувгаар энэ чиглэлийн контент бэлтгэж сурталчлах. | Урьдчилан сэргийлэх чиглэл бүхий мессеж, контент хийгдсэн байна. | Хийгдсэн мессеж, контентийн тоо | Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл | Цагдаагийн газар | 06 сар 09 сар | 500.000 |
| 1.2. | Архидалттай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээг тусгайлан шалгуур үзүүлэлт болгон сум, баг, байгууллагын ажил дүгнэх үзүүлэлтэд оруулж дүгнэх, дэмжих ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. | Сум, баг, байгууллагын ажил дүгнэх үзүүлэлтүүдэд шинэчлэл, нэмэлт хийгдсэн байна. | Архидалттай тэмцэх, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн ажил, арга хэмжээний тоо | Хууль, эрх зүйн хэлтэс | Сумдын Засаг даргын Тамгын газар | 12 сар | 500.000 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|--|--|---|---|---|---|------------------|-------------|
| 1.3. | Согтууруулах ундаа хэрэглэн тээврийн хэрэгсэл жолоодсоны улмаас эрүүл мэнд нь хохирч хөгжлийн бэрхшээлтэй болсон хүмүүсийг өөрсдийнх нь хүсэлтээр яриаг нь авч энэ төрлийн богино шторкууд хийж олон нийтийн сүлжээгээр давтамжтай дамжуулах. | Жилд 2 удаа шторк хийгдсэн байна. | Урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн шторкийн тоо | Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасаг | Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл | 06 сар 09 сар | - |
| 1.4. | Цахим орчинд "Би архи хэрэглэдэггүй" challenge өрнүүлэх | Challenge өрнүүлсэн байна | Challenge-д хамрагдсан иргэдийн тоо | Аймгийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл | Сумдын Засаг даргын Тамгын газар | 06 сар | - |
| <p>Зорилт 2: Архидан согтуурах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хяналт тавих арга хэмжээг иргэд, гэр бүл, төрөл садан, хамт олон, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн нэгдмэл хамтын үйл ажиллагаанд тулгуурлан зохион байгуулна.</p> | | | | | | | |
| 1. | Согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж орчиндоо айдас төрүүлдэг, удаа дараа эрүүлжүүлэгддэг архины хамаарал бүхий иргэдийг "Жаргалтай амьдрал төв"-д холбон зуучилж, нийгэм, сэтгэл зүйн үйлчилгээнд хамруулах. | Архинд донтох өвчтэй иргэдийг эмчилгээнд хамруулсан байна. | Эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо | Аймгийн Цагдаагийн газар | Баянхонгор сумын ЗДТГ "Жаргалтай амьдрал" төв | Жилдээ | - |
| 2. | "Жаргалтай амьдрал төв"-ийн эмчилгээнд хамрагдаж архинд донтох эмгэгээсээ салсан иргэдийн сайн туршлагыг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх зорилгоор 12 дугаар сард "Өөрийгөө ялсан хүн" арга хэмжээг зохион байгуулж, улсын хэмжээнд сурталчлах. | "Өөрийгөө ялсан хүн" арга хэмжээг зохион байгуулна. | Зохион байгуулагдсан арга хэмжээний чанар, нөлөө | Баянхонгор сумын ЗДТГ | Аймгийн Цагдаагийн газар | 12 сар | 1.0 сая/төг |
| 3. | Архинд донтох өвчтэй хүн болон түүний гэр бүлийнхэнд эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагааг өргөжүүлж, энэ чиглэлээр гэр бүл, төрөл садан, хамт олны нөлөөлөл, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх чиглэлээр | Эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагаа хийгдсэн байна | Сэтгэл зүйн зөвлөгөө өгч, дэмжлэг үзүүлсэн үйл ажиллагааны тоо, чанар | Сумдын Засаг даргын Тамгын газар | Аймгийн Цагдаагийн газар | Жилдээ | - |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|--|---|---|----------------------------------|--|--------------|---------|
| | арга хэмжээ зохион байгуулах. | | | | | | |
| 4. | Архины хамаарлаа шийдвэрлэсэн болон эрсдэл бүхий хүмүүсийг дахин архи уухаас өөрийгөө хамгаалах арга ухаанд сургах, үүнд мэргэжлийн баг туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулах | Мэргэжлийн багаас тус иргэдэд туслалцаа үзүүлсэн байна. | Мэргэжлийн байин үзүүлсэн туслалцаа, үйл ажиллагааны тоо, чанар | Сумдын Засаг даргын Тамгын газар | Аймгийн Цагдаагийн газар | Жилдээ | 500.000 |
| Зорилт 3: Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр аж ахуйн нэгж байгууллага, төрийн бус байгууллагын санал, санаачилгыг дэмжинэ. | | | | | | | |
| 3.1 | Согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрлийг олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох талаар цагдаагийн байгууллагаас аймгийн Засаг даргад хүргүүлсэн санал, түүний шийдвэрлэлтийн талаар нэгдсэн бүртгэл хөтлөх. | Мэдээллийн сан бий болсон байна. | Журмын хэрэгжилтийн чанар | Цагдаагийн газар | Хууль, эрх зүйн хэлтэс | Жилдээ | - |
| 3.2. | Согтууруулах ундаагаар үйлчилдэг худалдан борлуулдаг аж ахуй нэгжүүдэд мэргэжлийн байгууллагуудтай хамтарсан хяналт шалгалт зохион байгуулах. | Хяналт шалгалт зохион байгуулагдсан байна. | Хяналт шалгалтын тоо, чанар | Цагдаагийн газар | Хууль хяналтын байгууллагууд | 6 сар 09 сар | - |
| 3.3. | Хууль, журам зөрчиж согтууруулах ундааг худалдан борлуулсан, үйлчилсэн аж ахуйн нэгжийн талаарх мэдээллийг иргэдээс төлбөртэй авах | Мэдээлэл өгсөн иргэдийн нууцлалыг хамгаалж энэ талаарх үйл ажиллагаа хэвшил болсон байна. | Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн бууралтын тоо | Цагдаагийн газар | Баянхонгор сумын Засаг даргын Тамгын газар | Жилдээ | 500.000 |